

## “ИХЭСИЙН ГАЗАР”-ЫН УТГА УЧИР ХИЙГЭЭД БИНДЭР ОВООНЫ ТАХИЛЫН АСУУДАЛД

С.ӨЛЗИЙБАЯР

**Товч агуулга:** МНТ-нд дурдагдсан “Ихэсийн газар” нь хожмын монгол сурвалжуудад Бөртэ чинойн очсон газар болох “Йэдийн газар” хэмээх хэлбэрээр давтагдсан бололтой. Түүнийг тахиx зан үйл Биндэр овооны тахилгаар уламжлагдан бусад нутгуудад тархах болсныг эдүгээ манай улсын баруун нутгийн ястнуудын дунд тахилгат овоог “индэр”, “ендэр” хэмээн нэрлэсээр байгаагаас харж болно. “Дээр мөргөх” ёслол нь эртний Ихэсийн газрын тахилгын цээрлэсэн хэлбэр бололтой. Тиймээс Биндэрийн овооны тахилга бол Монголчуудын хамгийн эртний угшилтай, монгол газраа эзэн болсон Ихэс дээдсийнхээ сүр сүлдэд өргөж буй учир агуулгатай бөгөөд түүнийг Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Чингис (Өглөгч)-ийн хэрэм гэж бид үзсэн билээ.

**Түлхүүр үг:** Ихэсийн газар, Биндэр, индэр, дээр мөргөх

ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн “Онон” хээрийн судалгааны баг 2014-2016 онуудад Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Чингис (Өглөгч)-ийн хэрэм, түүний ойр тойронд археологи, угсаатан, түүхэн газар зүйн чиглэлийн судалгаа амжилттай хэрэгжүүлсээр ирсэн билээ. Судалгааны үр дүнд монголчуудын угсаа гарвалын түүхэнд нэн ач холбогдолтой байж болохуйц зарим шинэлэг дүгнэлтэд хүрсэн талаар бид өмнө нийтлүүлсээр ирсэн болно. Тухайлбал, энд хийсэн малтлагаар Киданы байгууламж гэж үзсээр ирснийг урагшлуулан НТ VIII зуунаас хожуугүй болохыг тогтоож, Онон голын адаг орчмын нутгаас өгсөн ирж, Бурхан халдун уулнаа төвхнөсөн монгол хэлт аймгууд босгосон байж болох таамаг дэвшүүлсэн. Мөн “Их хориг”, “Ихэсийн газар” хэмээх Монголчуудын түүхэнд нэр хүндтэй ариун газар орныг нэг утгаар ойлгож байсныг залруулах оролдлого хийж, Бөртэ чиной тэргүүт өвөг дээдэс, ихэс нь энэ нутагт тэмцэн ирж, голомтоо бадраасан нутаг учраас тэдний үр хойчис “Ихэсийн газар” хэмээн

онцгойлон үзэж, тахилга хийсээр байсан тухай санал дэвшүүлсэн. Чингис (Өглөгч)-ийн хэрмийг МНТ-нд дурдагдсан “Ихэсийн газар” гэж үзсэн түүхэн газар зүйн судалгаа үндэслэлтэй болох ба хожмын монгол сурвалжуудад Бөртэ чинойн нүүдэллэн очсон “Ж(з)эдийн газар”, “Йэ (Йа)дийн далан” гэх мэтээр бичигдсэн газар орон мөн байж болох тухай таамаг дэвшүүлсэн судалгааны үгүүлэл цөөнгүй хэвлүүлсэн билээ<sup>1</sup>. Тиймээс өмнө нийтлүүлсэн судалгааны үр дүнгийн талаар нуршин үгүүлэхээс зайлсхийж, зарим нэгэн шинэ тайлбар, сэдвийг энэ удаад хөндөх зорилт тавьсан болно.

Бид монгол сурвалжуудад тэмдэглэгдсэн “Jad-un qajar” болон “yad-un qajar” (Дарма гүүш. Алтан хүрдэн мянган хигээст), “yad-un dalang” (Рашпунцаг. Болор-Эрих) хэмээх түүхэн газар орны “jad” хэмээх нэрийн талаар судлаачдын таамаг хийгээд өөрсдийн тайлбарыг хийсэн билээ. Ж(з)ад, Ж(з)эд, Иэд, Иад гэх зэргээр хоёр янзаар бичигдсэн<sup>2\*</sup> нэг газрын нэрийг зөвхөн эхний хувилбараар уншин түрэгийн “харь” хэмээх үг гэж орчуулан ойлгох нь бараг тогтоод байгаагийн зэрэгцээ аймгийн нэр, задын зан үйл гүйцэтгэх газар зэрэг утгаар тайлбарласан билээ. Бид ч өмнө энэ үгийг эртний түрэгийн “дурсгал, санан дурсах” хэмээх утгаар тайлбарлах оролдлого хийсэн билээ<sup>3</sup>. Гэтэл монгол бичгийн хэлний хөгжил өндөр төвшинд хүрсэн XVII-XVIII зууны үед улам бүр алсран холдсон эртний түрэг үгээр монгол сурвалжуудад Бөртэ чинойн хүрсэн газрыг нэрлэсэн гэдэг нь баахан эргэлзээтэй санагдана. Харин энэ удаад хоёр дугаар хувилбар буюу “yad, yed” (Йэдийн газар) гэх үгийн талаар товч санаа дэвшүүлэх оролдлого хийв. Монгол хэлэнд олон тооны “д, с” дагавар сэлгүүцдэг тул “д”, “с” гарал язгуур нэг байж мэдэх<sup>4</sup> учраас МНТ-ны “yekes-e gajaru” (Ихэсийн газар)-ын олон тооны “с” дагавар “д”-р сэлгэгдсэн байх үндэстэй. Энэ тохиолдолд “yeked” хэмээх үг үүсэх ба эхлэл, төгсгөл 2 гийгүүлэгчийн дундах “ke” авиа сулран гээгдэж, “yed” хэмээх үг үүссэн бололтой. Монгол хэлэнд “ye” язгуур “их”-ийн хэмжээг илэрхийлэх

<sup>1</sup> Улзибаяр, С. “Памятник Бурхотуйской культуры в бассейне р. Хурха”, - *Древние культуры Монголии и Байкальской Сибири*. Улан Уде: 2010, 290-296, Улзибаяр, С. “О различиях терминологии «yekes-egajaru» и «Великий Гурук». - *Древние культуры Монголии и Байкальской Сибири*. Материалы международной научной конференции. Вып №2. Иркутск, 2011, 485-490; Өлзийбаяр, С. Монголын нууц товчоон дахь “Ихэсийн газар”-ын талаар цөөн хэдэн үг”, *Studia Historica*. Tom. XL. fasc. 5. 2011, 80-90

<sup>2</sup> Эртний монгол хэлэнд “ja” “ya” гийгүүлэгч нэг бөгөөд дундад зууны үед авианы хувьд салсан ч бичгийн хэлбэрээр нэгдмэл байсан бололтой. Тиймээс хэрэг дээрээ Ж(з)ад, Ж(з)эд, Иэд, Иад гэж амилуулан унших нь ялгаагүй болно

<sup>3</sup> Өлзийбаяр, С. “Ихэсийн газар хийгээд Жадын газар”. - Дипломат харилцаа тогтоосны 25 жилийн ой, Монгол-Солонгосын шинжлэх ухааны хамтын ажиллагаа. ОУЭШХ-ын эмхтгэл. Сүүл: 2015, 43-51

<sup>4</sup> *Монгол үгсийн язгуурын толь*. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо: 1987, 2939

(ертөнц, ерөнхий, ер, ес гэх мэт) утга ч байж болох юм. Рашпунцагийн Болор-Эрих зохиолд Монголчуудын элэнц өвөг Бөртэ-Чинойг “*yed-un dalang*” (Йэдийн далан) хэмээх газар ирээд<sup>1</sup> гэж дурдсан нь Чингисийн хэрмийг шууд заасан гэж үзүүштэй.

Монгол сурвалжуудад нэр гарч буй Бөртэ Чинойн очсон өөр нэг газар бол “Бэдэ улс” юм. Түүнийг Бурхан халдун уул, Байгал далайн орчим байсан гэж харилцан адилгүй тэмдэглэжээ. П.Б.Коновалов энэ газрын талаар “Бөртэ-Чинойн иргэдтэй ойр төрөл, эртний бэйди нарын бий болгосон монгол угсааны ард түмний сууж байсан газар гэж хэлж болох юм. Хэдийгээр энэ нутгийг нарийн тодорхойлох бололцоогүй ч гэсэн харьцангуй байдлаар Байгал, Хөвсгөлийн хоорондын нутаг байх” гэжээ<sup>2</sup>. Гэхдээ эртний хятадын нүүдэлчдийг нэрлэх *бэй-ди* хэмээх үг түвд хэлэнд “бида, бэдэ” гэж дуудагдах болсонтой судлаачид үндсэндээ санал нэгтэй ч чухам хаана байсныг тохоон заасан судалгаа хомс байна. Монгол сурвалжуудын мэдээнд тус хоёр газрын байрлал ойролцоо, эсвэл нэгэн нэрийг хэд хэдэн янзаар (*jad, yad, bede* гм) тэмдэглэсэн хэлбэр ч мэт ойлгогдохоор байна. МНТ-нд Йэхэсийн газар хэмээн тахилга үйлдэж байсан газрыг хожмын монгол сурвалжуудад Йэдийн газар (Йэдийн далан) гэж бичсэн бол МНТ-нд “бэдэ” хэмээх газрын нэрийг мөн тэмдэглэсэн байх магадлал бий. “Йэхэсийн газар”-ыг биднийхээр эдүгээ Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Чингис (Өглөгч)-ийн хэрэм мөн гэж үзвэл түүний ойр орчимд “Бэдэ” нэртэй холбогдох газар орны нэр хадгалагдсан байх үндэслэлтэй билээ. МНТ-нд дээрхтэй бичлэгийн хувьд төслөг ганц нэр бол Бэдэр хошуу (*beder-qosi'un-u*) болно. 88-р зүйлд “Тэмүжин ... Онон мөрөн өөд мөр мөшгив. Өрнөөс Химурга горхин орж ирэн ажгуу. Тэр өөд мөшгөөд, Химурга горхины Бэдэр хошууны Хорчухуй болдогт бүхүйд золголдов”<sup>3</sup> хэмээн дурдагдсан Бэдэр гэгдэх хошуу нь өнөөгийн Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Биндэрьяа уул мөн гэж олон судлаачид үзэж байна. МНТ-ны үеийн энэ нэр хожмоо монгол түүхэн сурвалжуудад “бэдэ” хэмээн тэмдэглэгдсэн байх магадлал бас бий. Дашрамд дурдахад, Бөртэ-Чинойн ирсэн “*Йэдийн газар*” буюу МНТ-ны “*Ихэсийн газар*” болох Чингисийн хэрэм хийгээд энэхүү Биндэрьяа уулын зүүн шувтаргын хошуу хоорондоо 12 км-ийн зайтай болно.

Монгол нутагт оршиж асан эртний нүүдэлчдийн дунд их хэмжээний тахилга өргөж байсан баримт цөөнгүй. Тухайлбал, *Хуннуд* жил бүрийн хаврын тэргүүн

<sup>1</sup> Рашпунцаг. *Болор-Эрих (кирилл үсгээр хөрвүүлсэн эх)*. Улаанбаатар: 2006, 18

<sup>2</sup> Коновалов, П.Б. *Этнические аспекты истории Центральной Азии (Древность и средневековье)*. Улан-Удэ: 1999, 121.

<sup>3</sup> *МНТ*. Эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа. Улаанбаатар: 2006

сард бүх удирдагчдын хуран чуулсан багавтар наадмаар шаньюйд өргөл барин, тахилга өргөнө. Харин 5-р сард зун цагаар Лунчэнд хотлоороо хуран чуулж, их наадам хийх ба ихэсдээдэс, тэнгэр, газар, хүн болон тэнгэрийн сүнсэнд тахилга өргөнө. Намар цагт адуу мал тарга тэвээрэг авах үед Дайлинд өргөнөөр цуглан их наадам үүсгэн мал, хүн амынхаа тоог бүртгэн тэмдэглэдэг байжээ. Хүннүгийн тусгай аймаг гэгдэх *Өндөр тэрэгтэн* нүүдэлчдийн дунд аянга буусан газарт хар хониор тахил өргөх, хотлоороо хуран чуулж, дуулан бүжиглэж, тэнгэрт тахилга өргөж байсан зэрэг сонирхолтой мэдээнүүд байна<sup>1</sup>. Иймэрхүү тахилгын ул мөр хүннүгээс ч өмнө хүрэл төмрийн түрүү эрин үеийн дурсгалуудад бий. Тухайн цагт хийгдэж байсан хүний оршуулгын голлох хэлбэр болох дөрвөлжин булш, хиргисүүрийг дуурайлган үйлдсэн олон арван тахилын байгууламжууд илэрч байгаа нь үүний илрэл болно. Хүннүчүүдийн дунд тэмдэглэгдсэн тахилга нь бүхэлдээ өвөг дээдсийн сүнс, сүлдийг эрхэмлэсэн Тэнгэр шүтлэгтэй холбогдож байна. Уйгурын гарлын домогт Хүннүгийн шаньюй ер бусын үзэсгэлэнтэй хоёр охинтой бөгөөд улс иргэн нь тэднийг бурхдын охид гэдэг. Шаньюй “нэгэнт надад ийм охид байгаа учир би тэднийг [жирийн] эрд эхнэр болгож болно гэжүү? Би тэднийг тэнгэрт барья” гэж шулууджээ. Үүний дараа улсынхаа умардад хүнгүй зэлүүд газар өндөрт оромж зэхэн охидоо суулган “Тэнгэр минь тэднийг таалан соёрхоно уу” хэмээн шившсэн<sup>2</sup> талаар сурвалжид дурджээ. Мөн Хүннүгийн нэгэн цаг үед оршиж асан эртний монгол хэлт аймаг *ухуаньчууд* үхэгсэдээ оршуулдаг нэгэн өвөрмөц заншилтай байсан талаар сурвалжид дурджээ. Тэд нас барсан хүнийхээ хувцас, эд юмс бүгдийг шатаагаад түүний унаж байсан морь болон хурц өнгийн хялгасан хүзүүвчтэй тэжээмэл (тусгайлан сургасан-С.Ө) нохойг барина. Учир нь нас барагчийн сүнсийг нохой даадаг ба Чишань (Улаан уул) ууланд хүргэдэг гэлцдэг. ... Дундад улсынхан Дай шань ууланд үхэгсэдийнхээ сүнсийг залахтай адил ажээ. Үхэгсэдийнхээ сүр сүлдэнд зориулан Тэнгэр, Газар, нар сар, од эрхэс, уул ус, өвөг дээдэст нь түүний алдар гавьяаг дуурсаж тахилга өргөдөг байна. Тахилгад бод болон хонийг өргөх ба ёслолын хаалтын үеэр бүгдийг шатаах маягаар тахилгын ёсыг гүйцэтгэнэ<sup>3</sup>.

Эндээс үзэхэд монголчуудын дээд өвөг эртний нүүдэлчдийн дунд Тэнгэрт тахилга өргөхдөө өндөрлөг буюу Тэнгэрт ойр ноёлог уулсыг чухалчлах үзэл

<sup>1</sup> *Материалы по истории Сюнну (по китайским источникам)*. Предисловие, перевод и примечания В.С.Таскина. Москва: 1968, 40., *Материалы по истории древних кочевых народов группы дунху*. Введение, перевод и комментарии В.С. Таскина. Москва: 1984, 403

<sup>2</sup> Таскин, В.С. *Материалы по истории древних кочевых народов группы дунху*. Москва: 1984, 401

<sup>3</sup> Таскин, В.С. *Материалы по истории древних кочевых народов группы дунху*. Москва: 1984, 64

хэдийн тогтоод байжээ. Эдүгээ манай ард түмний дунд уламжлагдаад байгаа өндөр уулыг тахих зан үйл эртний Тэнгэр шүтлэгийн улбаа бололтой. Харин олон монголчуудын дунд хамгийн өргөн дэлгэрээд буй *овоо тахилга* бол агуулгын хувьд Тэнгэр шүтлэгээс эрс өөр болой.МНТ-ны “*Ихэсийн газар*”-ын тахилга нь өвөг дээдсийн сүр сүлдийг тодорхой газар оронд (анх ирэн голомтоо бадраасан газар) шингээж байгаагаараа өмнөх үеийнхний өвөг дээдэс шүтлэгээс агуулгын хувьд хавьгүй өргөн, гүнзгий далд утгатай болжээ.

МНТ-ны &70-р зүйлд хавар цагт хатад *Ихэсийн газарт* очиж тахилга хийсэн тухай мэдээ нь Монголчуудын тахилгын зан үйлийн талаар дурдсан хамгийн эрт үед холбогдох баримт болно. Язгууртан овгууд өөрийн эрх мэдэл, сүр хүч, ноёлох байр сууриа хадгалах үүднээс сүлд, хийморио даатгасан шүтээнтэй байх шаардлага, хэрэгцээ зайлшгүй урган гарах тул аугаа өвөг дээдсийнхээ сүр хүчийг дээдлэн анхлан голомтоо бадраасан нутагт нь шүтэн жил бүрийн хавар цагт ирж их тахилга хийх шалтгаан болсон бололтой. Тиймээс “*Ихэсийн газар*”-ын тахилга нь өвөг дээдсийн шарил нутаглуулсан онгонд зориулагдсан хэмээн судлаачид үзсээр байгаа нь ташаа болох бөгөөд харин Бөртэ чиной тэргүүт монгол аймгууд Бурхан халдун уулнаа ирж, голомтоо бадраасан ихэс дээдсийн ариун газарт өргөж буй тахилга мөн гэж үзүүштэй юм.

Энэхүү тахилга МНТ бичигдэх үед байгалийн бэрх саад бүхий “*Ихэсийн газар*”-дээр анхлан шууд хийгдэж байсан бол аажмаар харьцангуй зам дагуу орших Биндэрийн овоонд шилжсэнээр агуулгын талаар улам баяжсан байна. Энд анх удаа ***өвөг дээдсийн сүнс сүлд, хийморийг уул овоонд шингээж үзэх төсөөлөл*** бий болсон бололтой. Өөрөөр хэлбэл, Биндэр овооны тахилгын язгуур утга буюу цаад эзэн нь Чингис хааны дээд өвөг Бөртэ чиной тэргүүт [язгуур] монголчууд болно. Уул овоог амьдчилан үзэх сэтгэлгээ чухам энэ үед төлөвшсөн болохыг дундад үеийн монголчуудын үлдээсэн оршуулгын зан үйлээс ч харагдана. Тухайлбал, энгэр газар, уулынхаа оройг чиглүүлэн тавих ёс бидний дунд эдүгээ ч хадгалагдсаар байгаа билээ. Энэ нь талийгчийнхаа сүнс, сүлдийг тухайн ууландаа шингээж, оршоож буй далд утгатай бололтой. Тиймээс “*Ихэсийн газар*”-ын тахилга Биндэр овоонд шилжсэн үйл явц, монголчуудын дунд талийгчийг уулын орой чиглүүлэх зан үйлийн дэлгэрэлт хоёр нэгэн цаг үед холбогдох нь зүй ёсны хэрэг билээ. Чухам л энэ цагаас эхлэн овоо тахих зан үйлийн эхлэл тавигдсан бололтой бөгөөд магадгүй хамгийн эртнийх нь ийнхүү Биндэр овооны тахилга бололтой байна.

Өнөө хир МНТ-ны нэрээ бараг хэвээр хадгалан байгаа Биндэрьяа уулын зүүн шувтарга дээрх Биндэрийн овоо нь бүс нутгийн хүрээнд хамгийн том тахилгат газар болно. Чухам хэзээнээс угшилтай нь тодорхой бус боловч Өндөр гэгээн Ононгийн халуун рашаанд морилоод буцах замдаа энд саатан “*Ихэсийн газар*”-өршөөсөн газар гэж тахисан тухай яриа бий<sup>1</sup>. 1960-аад онд энэ хавь нутагт судалгаа хийсэн Германы эрдэмтэн И.Щуберт тэмдэглэхдээ “Биндэрийн овоо нь дөрвөлжин хэлбэртэй шавар хашлагын дунд чулуу дүүргэн овоолсон ба түүний гадуур олон мөчрөөр хүрээлүүлсэн байна. Түүний дөрвөн зүгт буюу хойд, өмнөд этгээдэд тус бүр 16, зүүн талд 21 жижиг овоо байгааг би тоолов. Төв овоонд маанийн 6 үсэг болон төвд бичигтэй олон янзын цаас, “хийморийн” дарцаг тэргүүтнээр дүүрэн байв. ... Биндэр овоо нь Чингис хааны домогтой холбогддог. Энэ нь цагтаа нэлээн алдартай тахил болон мөргөлийн газар байжээ. Биндэр овооны дор жаран хонь, жаран дөрвөн үхрийг булсан гэдэг”<sup>2</sup> гэжээ. Игорь де Рахевильтз 1997 оны 8-р сард Чингис хааны түүхт газар нутгаар аялан явж, тэмдэглэл тайлбарын хамт хэвлүүлжээ. Тэрээр И.Щуберт, Х.Пэрлээ нарын 1961 онд Бурхан халдун уулаар явсан мөрөөр аялан Их хааны түүхэнд холбогдох газар нутгийг үзэн танилцаж, Хэнтий хан уулыг Бурхан халдун гэж үзсэнийг дэмжсэн байна. Харин Монгол-Японы хамтарсан “Гурван гол” экспедицийн тайланд дурдсан түүхэн газрын талаар саналаа үгүүлэх далимд Биндэр уулыг хоёр ч удаа тахисан баримт байх ба нэг нь Чингис хаанд, нөгөө нь ламын шашны зан үйлд зориулсан нь бас л учиртай байж болох юм. Хамгийн сүүлийн тахилга нь 1927 онд болсон гэдэг<sup>3</sup> мэдээг дурджээ. МНТ-нд дурдагдсан “Ихэсийн газар” буюу өнөөгийн Чингисийн хэрэм, Биндэр овоо хоорондоо ойр байрлаж байгаа хийгээд Биндэр овооны Чингис хаантай холбогдож буй аман домог, тахилгын зан үйлийн агуулгаас үзэхэд Ихэсийн газрын тахилга хожим Биндэрийн овоонд шилжсэн байх магадлалтайг дам харуулж байна. Тухайлбал, Биндэр овоог Чингис хаанд зориулан тахиж байсан гэгдэх эл аман мэдээ нь МНТ-ны &70-р зүйлд дурдсан “*Ихэсийн газар*”-т өргөж байсан тахилгаас үүдэлтэй байж болно. Асуудлын гол нь МНТ-ны “*Ихэсийн газар*”-ын тахилга бол ямар нэг лус савдаг, газар усны эзэн, өвөг дээдсийн сүнс, сүлдэдбус Бөртэ чиной тэргүүт монголчуудын дээд өвөг Бурхан халдун ууланд ирж **голомтоо бадраасан газар орон** буюу Ихэс дээдсийн газарт өргөж буй зан үйл юм. Биндэр овооны тахилга нь ийнхүү Ихэсийн газрын

<sup>1</sup> www.mpa.gov.mn

<sup>2</sup> Johannes Schubert. *Ritt zum Burchan-chaldun*. Leipzig: 1963, 61

<sup>3</sup> Igor de Rachewiltz. “Searching for Chinggis khan: notes and comments on historic sites Hentii aimag, northern Mongolia”, *Rivista degli Studi orientali*. Vol. LXXI. Fasc. 1-4. 1998, 239-256

тахилгын уламжлал гэж үзвэл Бурхны шашин нэвтрэхээс өмнөх үед монголчуудын дээд өвөг, хожимдоо Чингис хааны сүнс, сүлдний тахилгатай холбогдож байсан нь тодорхой юм. Ихэсийн газраас улбаалсан эртний тахилгын ул мөр манай орны зарим нутгуудад эдүгээ хадгалагдсаар байгаа бололтой.

Баруун зүгийн аймгуудын зарим ястны дунд тахилгын овоог *индэр (ендэр)*, түүнд хийх зан үйлийг “*дээр мөргөх*” гэж нарийн дэг жаягтай ёс хадгалагдан үлджээ. Тухайлбал, угсаатны зүйч Т.Дисан 1987 онд өөлд ястан 73 настай Б.Цэвэгжаваас шинийн 1-нд гүйцэтгэдэг “*дээр мөргөх*” тухай яриа тэмдэглэн авчээ. Тэрээр “дээр мөргөнө гэдэг нь тэр мөргөх индэрээ дээр газар байгуулсан учир тэр өндрөөрөө 1,5-2м, диаметр нь 1,5 м чулуугаар засаж янзалсан байдаг. Дээр нь мод харгана, бургас босгоод хадаг яндар эсвэл хэв зүүнэ. Мөргөхдөө бүгд нарнаар мөргөнө. ... индэрийг нар гарах зүүн өмнө зүг өндөр газар дээр нар хамгийн түрүүн гарах газар хийсэн байдаг. Нэг хот айл нэг л индэр байна” гэжээ<sup>1</sup>. Угсаатан зүйч Ц.Аюуш “Дөрвөдүүд сар шинийн өглөө бэлдсэн овоонд мөргөл үйлдэх буюу нутгийнхны ярьдгаар “дээр мөргөх” тахилын зан үйлээс эхэлдэг. Бидний ойлгосноор “дээр” гэдэг үгийг дөрвөдүүд “газар дэлхий” гэсэн утгаар ойлгож төсөөлж байна. ... индэрийн галд өргөх өвчүү юм уу, хавирга заавал авчирдаг” бол Д.Нансалмаагийн тэмдэглэснээс мянгадууд “...мөн битүүний орой урд зүгт гэрийнхээ үүдийг голлоод шинийн нэгэнд “*дээр мөргөх*”-д бэлтгэн индэр засдаг”<sup>2</sup> ажээ. Шинийн нэгний өглөө ийнхүү овоон дээрээ гарч тахилга хийх нь нийт Монголчуудын дунд үлдсэн тогтвортой зан үйлийн нэг бөгөөд манай баруун хэсэгт энэхүү овоог “индэр” гэх нэршил үлджээ. Индэр дээр хийж гүйцэтгэх зан үйл нарийн дэг жаягтай бөгөөд “... гал асааж дээр нь өвчүү, дөрвөн өндөртэй хавирга мөн цагаан идээнийхээ дээжээс оруулж, цагаан ямбуунд ороон тавьж шатаадаг”<sup>3</sup> байна. Үйлдэж байгаа зан үйл, дэг жаягийн талаар ийнхүү тогтсон журамтай ихээхэн боловсронгуй болсон нь эртний уламжлалтай болохыг харуулах юм.

“Дээр мөргөх” зан үйлийг гүйцэтгэж байгаа *индэр (ендэр)* нэрийн үүслийн асуудал бидний сонирхлыг ихээхэн татаж буй болно. Энэ тахилга хийгээд нэр нь Биндэр овооны буюу “*Ихэсийн газар*”-ын тахилгын зан үйлийн улбаа бус уу? Г.Мэнэс “... олон Монголчуудын дунд “Дээр” хэмээх нэгэн их шүтээн байсан

<sup>1</sup> Дисан, Т. “1987 онд Улаанбаатар хотод амьдарч буй Ховдын харъяат өөлд ястны дунд ажилласан угсаатны зүйн тайлан, эх хэрэглэгдэхүүн”. - *Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн*. Т.ИХ. Улаанбаатар: 2011, 194

<sup>2</sup> Мэнэс, Г. “Монголын нууц товчоон” дахь эхний хоёр мөрийн оньсого буюу “Чингис хааны язгуур” хэмээх гарчиг нэрийг нягтлах нь”, *Угсаатан судлал (SE)*. Т.XV, fasc.8, 2003

<sup>3</sup> Жаргалсайхан, Б. “Овоо тахих (Дээр мөргөх) ёсон”, *Түүхийн товчоон*. Т.VI, Fasc 37, 2012, 228-239



бөгөөд түүндээ мөргөн залбирахыг “Дээр мөргөх” хэмээн цээр бололтой нэрээр өргөмжлөн дуудах нь түгээмэл зан үйлийн нэг байсан бололтой”<sup>1</sup> хэмээн үзэхэд хүрсэн нь үүний учир холбогдолтой мэт. Магадгүй, XIII зууны үед Бурхан халдунаар нутаглаж асан Урианхайчууд Алтай нутагт энэхүү Биндэр овооны (Ихэсийн газрын) тахилгыг аваачсан ч байж болох юм. Ямар ч замаар байсан энэ тахилга Алтай нутагт нэвтрэхдээ язгуурын *Бэдэр (Биндэр)* нэрээ хадгалсаар байгаагийн илрэл *индэр (ендэр)* хэмээх нэр мөн гэж үзлээ. Монгол хатдын Ихэс дээдсийн голомтыг тахих зан үйлийн утга учир өвлөгдсөөр байгаа нь ийнхүү “Дээр мөргөх” зан үйлээр илэрч байгаа бололтой. Монгол хэлэнд үгийн эхэнд дуудагдах “б” авиа сулран гээгдэх жишээ эрт цагт байсан нь XIV зууны тэргүүн хагаст бичигдсэн Рашид ад Диний “Судрын чуулган”-д *бэсүд* аймгийн нэрийг *бисут, ийсут* болон *исут*<sup>2</sup> гэх мэтээр тэмдэглэжээ. Мөн дундад зууны үед бэдэр нэрээс үүдэлтэй газрын нэрийн жишээнд Халхын Засагт хан аймгийн чуулган хуралдсан газар “Засаг арван есөн. Заг гол /*jaγγoal*/-ын эх Бидэрьяа нуур /*bidüriy-a naγur*/ газарт чуулган нийлүүлмүй”<sup>3</sup> хэмээн тэмдэглэгдсэнээс харж болох байна.

Нутгийнхан нэрлэж заншсан “*Чингисийн хэрэм*” хэмээх нэрийн талаар цөөн хэдэн зүйл дашрамд дурдъя. Ж.Бадамдаш 1980-аад он дундуур нийтлүүлсэн үгүүлэлдээ Чингис хааны түүхэнд огт холбогдохгүй хэрмийг “Чингисийн” хэмээн нэрлэсээр ирсэн нь ихээхэн утгагүй зүйл болох талаар дурдсан байдаг<sup>4</sup>. Эндээс үзэхэд энэ нэршил үзэл суртлын хаалттай цагт бий болоогүй нь лавтай бөгөөд үүнээс өмнө ч байсан нь илт юм. 1928 онд С.В.Кондратьев энд ирж, тус хэрмийн урдуур урсах голын нэрээр “Өглөгчийн” гэж нэрлэсэн нь судалгааны зохиолуудад эдүгээ хэвшил болсон тал байна. Хэрмийн уг нэр нь энэхүү гүн гүнзгий утга учир холбогдол бүхий тахилгат газрын зан үйлийн ул мөрийг хадгалсан нэршил болно.

Ийнхүү МНТ-нд тэмдэглэгдсэн “Ихэсийн газар”-ын тахилга нь Чингис хааны дээд өвөг монголчууд тэргүүн Ононы Бурхан халдун уулнаа эргэн ирж, голомтоо бадраасан газар орон (Чингисийн хэрэм орчим нутаг) –д зориулан өргөж байсан зан үйл юм. Харин Чингис хаанаас хойш “Ихэсийн газар”-ын тахилга нь Их хааны сүнс сүлдэд өргөх хэлбэртэй болж агуулгын хувьд баяжин, улмаар өнөөгийн Биндэр овоог тахих хэлбэрт шилжсэн бололтой. Олон монголчуудын дунд түгэн

<sup>1</sup> Мэнэс, Г. “Монголын нууц товчоон” дахь эхний хоёр мөрийн оньсого буюу “Чингис хааны язгуур” хэмээх гарчиг нэрийг нягтлах нь”, Угсаатан судлал (SE). Т.XV, facs.8, 2003.

<sup>2</sup> Рашид ад-Дин. *Сборник летописей Т. I. Книга первая*. М-Л., 1952. с. 193

<sup>3</sup> *Зарлигаар тогтоосон Гадаад Монгол, Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир II*. (манж, хятад эхтэй харгуулсан Ц.Цэрэндорж). Улаанбаатар: 2009, 74

<sup>4</sup> Бадамдаш Ж. “Дэлүүн болдог”, ШУАМ. № 4, 1989



дэлгэрсэн овоо тахих ёс нь язгуур утгаараа Ихэсийн газар хийгээд Их хааныхаа сүр сүлдэд өргөх тахилгын агуулгатай болно. Үүний илрэл нь баруун зүгийн нутгаар хадгалагдсан “индэр” засах, “дээр мөргөх” гэх зэрэг зан үйл бололтой.

**Abstract:** In “Compendium of Chronicles”, the unique source of Mongolian history in Persian language it was written as the burials of the khans whose genesis derives from Tului, Khubilai and Munkh khans are situated in “Big khorig (Big forbidden zone)” and these are guarded by the Uriankhais, the forest tribe precisely and it was mentioned about the Spring offerings in the “Ikhesin gazar (Place of noblemen)” in “The secret history of the Mongols”. Most of the domestic and foreign researchers understand the places mentioned in two sources are same with the meaning of the “places where noblemen buried”. However, “Ikhesin gazar (Place of noblemen)” is not the place where noblemen were buried but the place where Mongols headed by Borte-Chinoi came to the Burkhan khaldun mountain, making it their heart place as owners and therefore their following generation named this place in such way as I, the weak author said before. This “Ikhesin gazar (Place of noblemen)” is the Chinges`s wall (it is mentioned in the research works as Uglugh`s being called by the river name) in Batshireet soum, Khentii aimag that is proved by the burials of deceased people who formerly came from the places in the beginning, middle and end of the Onon river and radio carbonic analyze results of the samples taken from the bottoms of dwellings here and the wall which were efforts by the author publishing materials before it.

The place named as “Jediin gazar”, “Jediin dalan” is the place where Borte Chinoi came that was written in the sources from XVI to XVII centuries is the “Ikhesin gazar (Place of noblemen)” mentioned in “The secret history of the Mongols” according to our conclusion.

In this time we consider that the sound “khe” of the word “Yekhese gazaru” was lost when it had the plural suffixes of Mongolian language “-s” or “-d” which are variant suffixes. Therefore, word “Yekhese” became “Yese” or “Yede” forming word combination “Yedun gazaru”, “Yedun dalang”. Suffix “-un” has possessive meaning. The name “Yedun gazaru” was written in the later Mongolian sources. If this derivation has real reason, the toponym “bide”/“bede” that is written with the word “Yedun gazaru” as the word combination has to be considered and the localization of this place must be determined. The toponym “bede” is the name of

the place “Beder khoshuu” that was written in “The secret history of the Mongols” as we consider. The Beder/bede is Bider, the eastern cape of the nowadays mountain Bideriya. The Binder ovoo on the Bider cape is situated at 12-13 km from the “Ikhesiin gazar” and this ovoo can keep the ancient offering tradition. Therefore, the offering on the Binder ovoo is the most ancient one because this is the heart place of the Chingis khan`s ancestors who moved here. For example, nowadays the western Mongolians name ovoo on the mountain as “inder”/“yender”/ that is derived from the word “binder”, the name of the first offering ovoo.